



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 69

Улаанбаатар хот

Түр журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27<sup>1</sup> дүгээр зүйлийн 27<sup>1</sup>.1.1, 27<sup>1</sup>.1.4, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гадаад улсаас ирсэн хүнийг тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ыг хавсралтаар баталсугай.


2. Энэ тушаалын хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд (Л.Халтар), Эрүүл мэндийн сайд (С.Энхболд), Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга (Т.Гантулга), Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал (Ж.Болд) нарт тус тус даалгасугай.

3. Батлагдсан түр журмыг хэрэгжүүлж ажиллахыг Улсын онцгой комиссын Нэгдсэн шуурхай штаб, аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комиссын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал (Г.Ариунбуян)-д даалгасугай.

ДАРГА

С.АМАРСАЙХАН



ГАДААД УЛСААС ИРСЭН ХҮНИЙГ ТУСГААРЛАН АЖИГЛАХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү түр журмын зорилго нь Коронавируст халдвар (КОВИД-19)-ын мутацилагдсан хувилбарын тархалт өндөртэй бүс нутгаас ирсэн, дамжин өнгөрсөн хүн (Монгол Улсын болон гадаадын бүх насны хүн), хилийн нэвтрэх цэгт түргэвчилсэн эерэг гарсан бх-ПГУ шинжилгээний хариу гарах хүртэл хугацаанд, ойрын хавьтал болсон хүнийг тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохион байгуулах, халдвараас сэргийлэх, аюулгүй байдал, эрүүл ахуйн дэглэмийг мөрдүүлэхэд оршино.

1.2. Тусгаарлан ажиглах үйл ажиллагаанд Гамшгаас хамгаалах тухай хууль, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдлөг болгоно.

1.3. "Тусгаарлан ажиглах" гэж гадаад улсаас ирсэн хүнийг тусгай шаардлагын дагуу урьдчилан бэлтгэсэн түр байранд тусгаарлан ажиглах, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хяналтад байлгахыг хэлнэ.

1.4. Тусгаарлан ажиглах үйл ажиллагааг улс, нийслэлийн хэмжээнд Улсын онцгой комиссын Нэгдсэн Шуурхай штаб /цаашид "УОКНШШ" гэх/, орон нутагт аймаг, сумын онцгой комиссын Шуурхай штаб /цаашид "АСШШ" гэх/ нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.

1.5. Тусгаарлан ажиглах үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

1.5.1. Хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах;

1.5.2. Хууль дээдлэх, хүний эрхийг хангах;

1.5.3. Шуурхай, ил тод байх;

1.5.4. Хувь хүний нууцыг чанд хадгалах;

1.5.5. Байгууллага хоорондын хамтын ажиллагааг хангах;

1.5.6. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

1.5.7. Тусгаарлан ажиглах түр байрны нэг өрөөнд нэг хүн, нэг гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хамтран амьдрагчийг хамтад нь байрлуулах;

**Хоёр. Тусгаарлан ажиглалтын зохион байгуулалт, шинжилгээ, хугацаа**

2.1. Гадаад улсаас ирэх хүнийг Монгол Улсын хилээр нэвтрэх, өөр улс орноос дамжин ирсэн, дамжиж өнгөрсөн хугацааг урьдчилан тооцож ямар ч тохиолдолд 72 цагийн хүчинтэй бх-ПГУ-ын шинжилгээний "сөрөг" эсхүл дээрх хугацаанд өгсөн "бх-ПГУ" шинжилгээ нь "эерэг" гарсан тохиолдолд сүүлийн 4 сарын хугацаанд коронавируст халдвар (Ковид-19) авч эмчлэгдэн, эдгэрснийг нотлох баримт бичиг, авто замын боомтоор улс хоорондын тээвэр гүйцэтгэгч жолоочийн 48 цагийн түргэвчилсэн шинжилгээний хариунд тус тус үндэслэн нэвтрүүлэх, нислэгт багтаах, зөрчсөн, эрсдэл үүссэн тохиолдолд гарах бүх зардал, хариуцлагыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж, хүн бүрэн хариуцна.

2.2. Энэхүү журмын 2.1-т тавигдах шаардлагыг хангаагүй, шинжилгээгүй хүнийг нислэгт багтаах зэрэгтэй холбоотой үүсэх эрсдэл, гарах бүх зардал, хариуцлагыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж, хүн бүрэн хариуцна.

2.3. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас SARS-CoV-2 анхаарал татаж буй вирусийн хувилбар бүртгэгдсэн улс орны жагсаалтыг шинэчлэн [www.moh.gov.mn](http://www.moh.gov.mn) цахим хуудасны "travel info" цэсэд байршуулна.

2.4. Агаарын тээврийн компани нь гадаад улсаас ирэх хүний дархлаажуулалтын бүрэн тун авсан эсэх, өөр бусад улс орноор дамжин ирж байгаа эсэхийг нарийвчлан тодруулж, мэдээллийг УОК-ын Нэгдсэн шуурхай штабт хүргүүлнэ.

2.5. Хилийн боомтын нэвтрэх цэгт тухайн хүнд хийх тандалтыг Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 58 дугаар тушаалаар баталсан "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед хилийн боомтоор зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх журам"-ыг баримтлан хилийн мэргэжлийн хяналтын байгууллага хариуцан ажиллана.

2.6. Хил хамгаалах байгууллагын ажилтан нь халдвараас сэргийлэх дэглэмийг баримтлан, зорчигчийн биеийн байцаалтыг шалган, улсын хилээр нэвтрэх зөвшөөрөл олгоно.

2.7. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын мутацлагдсан хувилбар бүртгэгдсэн улс орноос ирсэн, дамжин өнгөрсөн болон халдварын шинж тэмдэгтэй, түргэвчилсэн шинжилгээгээр эерэг гарсан зорчигч, жолоочийн зорчсон тээврийн хэрэгсэл, ачаа, гар тээшийг тусгайлан бэлтгэсэн байранд, орон нутагт Зооноз өвчин судлалын төвийн мэргэжлийн баг (ЗӨСТ байхгүй тохиолдолд тухайн боомтын хилийн мэргэжлийн хяналтын байгууллага), "Чингис хаан" олон улсын нисэх буудалд тухайн боомтын хилийн мэргэжлийн алба халдваргүйжүүлэлтийг тус тус хариуцан хийнэ.

2.8. Эрүүл мэндийн хүндэтгэн үзэх шалтгаантай хүний өргөдлийг үндэслэн УОК-ын НШШ-ын зөвшөөрлийн дагуу нийслэлд Нэгдсэн шуурхай штабын ажиллагааны баг, аймаг орон нутагт АОК хариуцан холбогдох эрүүл мэндийн байгууллагад шилжүүлнэ.

2.9. Улс орны эдийн засаг, стратегийн чухал ач холбогдол бүхий асуудлаар албан томилолтоор ирж байгаа хүнийг байгууллагын хүсэлт, нотлох баримтыг үндэслэн УОК-ын НШШ-ын зөвшөөрлийн дагуу тухайн байгууллага хариуцан халдвараас сэргийлэх дэглэм баримтлан, нийслэлд Нэгдсэн шуурхай штабын ажиллагааны баг, аймаг орон нутагт АОК хяналт тавьж ажиллана.

2.10. Энэхүү журмын 2.3-т заагдсан болон дамжсан Монгол Улсын хүнийг тээврийн хэрэгсэлд суулгаж, цагдаагийн хамгаалалтад шилжүүлэн, тээвэрлэлтийг Цагдаагийн байгууллагын хамгаалалт дор зохион байгуулна.

2.11. Дараах тохиолдолд гадаадаас ирж байгаа хүнийг тусгаарлан ажиглах түр байранд тусгаарлана:

2.11.1. эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан анхаарал татаж буй SARS-CoV-2 вирусийн шинэ хувилбар бүртгэгдэж байгаа гадаад орны жагсаалтад багтсан орноос ирсэн болон дамжин өнгөрсөн хүнийг тусгаарлан ажиглах түр байранд 10 хоног;

2.11.2. SARS-CoV-2 вирусийн шинэ хувилбараар өвчилсөн хүнтэй ойрын хавьтал гэж тогтоогдсон тохиолдолд 10 хоног;

2.11.3. хилийн нэвтрэх цэгт түргэвчилсэн шинжилгээгээр эерэг хүнийг бх-ПГУ шинжилгээний хариу гарах хүртэл хугацаанд;

2.11.4. гадаад улсад зорчсон нисэх баг, төмөр замын зүтгүүрийн болон авто тээврийн бүрэлдэхүүн, жолооч хил нэвтэрсэн, хил нэвтрээгүй боловч халдвараас сэргийлэх дэглэм зөрчсөн бол тус баг, бүрэлдэхүүнийг 10 хоног;

2.11.5. эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан "SARS-CoV-2 вирусийн анхаарал татаж буй шинэ хувилбар бүртгэгдсэн улс орны жагсаалт"-д багтсан улсаас ирсэн Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгч, олон улсын байгууллагын суурин төлөөлөгч, ажилтан болон тэдгээрийн гэр бүл, Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгч, олон улсын байгууллагын суурин төлөөлөгч, ажилтан болон тэдгээрийн гэр бүлийг тухайн улсын дипломат төлөөлөгчийн газрын тусгайлан бэлтгэсэн байранд 10 хоног;

2.12. SARS-CoV-2 вирусийн анхаарал татаж буй шинэ хувилбар тархсан улс орноос болон өөр улс орноор дамжин ирсэн хүнээс хилийн боомтод шинжилгээ авсан эсэхээс үл хамааран тусгаарлалтын 4 ба 8 дахь хоногт бх-ПГУ шинжилгээг авах ажлыг нийслэлд Халдварт өвчин судлалын үндэсний төв /ХӨСҮТ/, Нийслэлийн эрүүл мэндийн газар, орон нутгийн эрүүл мэндийн байгууллага тус тус зохион байгуулна.

2.13. Тусгаарлагдах хугацаанд авсан ПГУ шинжилгээгээр коронавируст халдвар батлагдсан тохиолдолд тухайн хүнийг эмнэлэгт тусгаарлан эмчилнэ.

2.14. Тусгаарлан ажиглах түр байранд эрүүл мэнд, онцгой байдал, цагдаагийн байгууллагын алба хаагч, зохион байгуулагч, хувийн хэвшил, аж ахуйн нэгжийн үйлчилгээний ажилчид үүрэг гүйцэтгэнэ.

2.15. Тусгаарлан ажиглах түр байранд үүрэг гүйцэтгэж байгаа ажилтан, албан хаагчдаас коронавируст халдварын эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн, эсвэл шинжилгээний хариу "эерэг" гарсан тохиолдолд тусгаарлан ажиглах түр байрнаас бусад ажилчдыг гаргахыг тандалтын багийн дүгнэлтийг үндэслэн тухайн шатны Онцгой комиссын Шуурхай штаб шийдвэрлэнэ.

2.16. Тусгаарлан ажиглах түр байранд үүрэг гүйцэтгэж байгаад хугацаа (ээлж) дуусан гарч буй эрүүл мэнд, онцгой, цагдаагийн байгууллагын ажилтан гэртээ 4 хоног өөрийгөө ажиглаж, нийгмийн харилцаанд орохгүй, халдвараас сэргийлэх дэглэм баримтална.

### **Гурав. Тусгаарлан ажиглах түр байр, түүнд тавигдах шаардлага**

3.1. Тусгаарлан ажиглах түр байрыг дараах эрэмбээр сонгоно:

3.1.1. зочид буудал

3.1.2. амралтын газар, сувилал,

3.1.3. гадаад улсаас Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газрын байр

3.1.4. тусгаарлан ажиглах байраар ашиглахаар зориулалтыг өөрчлөн тохижуулсан байр

3.2. Тусгаарлан ажиглах түр байрыг сонгох ажлын хэсэг (Эрүүл мэнд, Мэргэжлийн хяналт, Онцгой байдал, Цагдаа)-ийг нийслэлд дүүргийн, аймаг орон нутаг, сумын Онцгой комиссын даргын тушаалаар томилно

3.3. Хуулийн этгээд нь өөрийн эзэмшлийн байрыг тусгаарлан ажиглах түр байрын зориулалтаар ашиглуулах хүсэлтээ ажлын хэсэгт гаргана. Ажлын хэсэг нь уг хүсэлтийг судлан үзэж, энэхүү журмын 3.1 дэх хэсэгт заасан шаардлагад нийцсэн объектыг тусгаарлан ажиглах түр байраар сонгох эсэхийг шийдвэрлэнэ;

3.4. Сонгогдсон байрны эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэмийн шаардлагад нийцсэн эсэх дүгнэлт, дэлгэрэнгүй мэдээллийг дүүрэг, аймгийн Онцгой комиссын томилсон ажлын хэсгээс УОКНШШ, сумын онцгой комисс нь аймгийн Онцгой комиссын Шуурхай штабт тус тус хүргүүлнэ;

3.5. Тусгаарлан ажиглах түр байрны эзэмшигчтэй байгуулах гэрээний загварыг онцгой байдлын газар боловсруулж, санхүүгийн төлбөр тооцооны гүйцэтгэлд хяналт тавина;

3.6. Тусгаарлан ажиглах байр нь дараах шаардлагыг хангасан байна:

3.6.1. цахилгаан, дулаан, усан хангамж, ариутгах татуургын төвлөрсөн болон хэсгийн системд холбогдсон, галын аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангасан байх;

3.6.2. ундны усны хэсгийн систем, эх үүсвэр, хэрэглээний шугамын усанд мэргэжлийн хяналтын байгууллагаар нян судлалын шинжилгээг хийлгэж, дүгнэлт гаргуулсан байх;

3.6.3. цонхны салхивчийг нээх боломжтой, эсвэл агааржуулалтын системтэй, бага насны хүүхдийн аюулгүй байдлыг хангасан байх;

3.6.4. өрөө тус бүр гар угаах нөхцөлөөр хангагдсан бие засах ариун цэврийн өрөөтэй, нэг өрөөнд энэхүү түр журамд заасан нөхцөлөөр хүнийг хамт тусгаарласан тохиолдолд ор хоорондын зайг нэг метрээс доошгүй байх;

3.6.5. эрүүл мэнд, онцгой байдал, цагдаагийн алба хаагчийн байрлах өрөө нь гар угаах, усанд орох, бие засах нөхцөлөөр хангагдсан эсвэл гар угаах, усанд орох хэсэг нь ажиглалтад байгаа хүнээс тусдаа байхаар зохион байгуулагдсан байх;

3.6.6. хяналтын камер, зарлан мэдээлэх төхөөрөмжийг давхар бүрд бүрэн хянах боломжтойгоор байрлуулсан, камерын бичлэг нь тусгаарлалтын нэг ээлжийн бичлэгийг бүрэн хадгалах хүчин чадалтай байх;

3.6.7. албан хаагчдын амрах, хоол үйлдвэрлэх, сэжигтэй тохиолдлыг түр тусгаарлах, цэвэрлэгээний материал угааж халдваргүйжүүлж, хадгалах өрөө, хамгаалах хувцас өмсөж, тайлах хэсэгтэй байх;

3.6.8. тусгаарлагдаж байгаа хүн, үүрэг гүйцэтгэж буй ажилтныг чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан хоол, хүнсээр хангах;

3.6.9. өрөө бүрд дараах эд зүйлийг урьдчилан бэлтгэж байршуулсан байх:

а/ариун цэврийн цаас, гарын болон эдийн саван, аяга, таваг угаагч шингэн, цэвэрлэгээний алчуур (гал тогооны, тоосны, шалны), өрөө, тасалгаа, ариун цэврийн өрөөнд хэрэглэх угаалга, цэвэрлэгээний бодис, хогийн сав, хар, шар өнгийн хогийн уут;

б/"Эмнэлзүйн шинж тэмдэг тандах хуудас", халуун хэмжигч (эмнэлгийн ажилтан халуун хэмжихээр зохицуулсан бол шаардлагагүй), эмч мэргэжилтэнтэй холбоо барих утасны жагсаалт, ажиглалтын үед мөрдөх санамж, гал түймэр болон ослын үед ашиглах аврах гарцын бүдүүвч зураг, хориглох зүйлсийн анхааруулга, цэвэрлэгээний зааварчилга, хог гаргах цагийн хуваарь;

в/хаалганы гадна талд хоол, эргэлтийн эд зүйлсийг тавих ширээ (сандаал, шүүгээ);

3.7. Энэ журмын 3.6.1-д заасан нөхцөл, шаардлага сум, тосгонд хамаарахгүй байж болно.

3.8. Хэсгийн усан хангамжтай тусгаарлан ажиглах түр байрны усны эх үүсвэр, ус түгээгүүрийн шугам сүлжээ, ус нөөцлөх санд холбогдох журмын дагуу хамгаалалтын бүс тогтоож, бохирдолтоос хамгаалах арга хэмжээг авч, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангана.

3.9. Зөөврийн усан хангамжтай тусгаарлан ажиглах байрны эх үүсвэрийн ус нөөцлөх савыг сэрүүний улиралд 3 сар, дулааны улиралд сар тутам, ус зөөвөрлөх хадгалах савыг долоо хоногт 2-оос доошгүй удаа угааж цэвэрлэн, халдваргүйжүүлнэ.

3.10. Хувцас тайлах хэсэгт толь, хамгаалах хувцас тайлах дарааллыг харуулсан зурагт хуудас, 50 литрээс дээш хэмжээтэй "Био аюултай" гэсэн тэмдэглэгээтэй шар өнгийн хогийн уут бүхий "хөл ажиллагаа"-тай хогийн сав зэргийг байрлуулсан байна.

3.11. Тусгаарлан ажиглах түр байрыг халдвартай-"улаан", халдварын эрсдэл дунд буюу завсрын-"шар", халдваргүй-"ногоон" гэсэн гурван бүсээр хуваана.

3.12. Тусгаарлан ажиглах түр байрны хяналтын камерын дэлгэцийг тухайн байрны "ногоон бүс"-д байрлуулна.

3.13. Эмч мэргэжилтэн, бусад алба хаагчийн байрлах өрөө, хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл тайлах хэсэг, гал тогооноос тусгаарлан ажиглах өрөөнд хоол зөөвөрлөх, хоолны хэрэгслийг гал тогоонд хүргэх болон хог хаягдлыг зөөвөрлөх чиглэл зэрэг орох, гарахыг хориглосон хэсэгт нэг чигийн урсгалаар хөдөлгөөнийг давхцуулахгүй байхаар анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байрлуулна.

3.14. Тусгаарлан ажиглах түр байрыг цагдаагийн байгууллагын хамгаалалтад авах бөгөөд гэрээт харуул хамгаалалт, камерын бүрэн хяналт бүхий тусгаарлан ажиглах байрны гадна орчинд цагдаагийн хамгаалалт гаргахгүй болно.

## **Дөрөв. Улс болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комиссын Шуурхай штабын эрх, үүрэг**

4.1. Улсын онцгой комиссын Нэгдсэн шуурхай штаб дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1. нийслэлд тусгаарлан ажиглах түр байрны бэлтгэлийг хангуулах;

4.1.2. тусгаарлах түр байранд ажиллах эрүүл мэнд, онцгой байдал, цагдаагийн байгууллагын ажилтны мэдээллийг холбогдох байгууллагуудаас авч нэгтгэн, ажиллах хүчний нөөцийг төлөвлөх;

4.1.3. тусгаарлан ажиглах түр байранд байгаа хүн /бага насны хүүхэд, тусгай хоолны дэглэмтэй хүн/-д олгох хоолны жишиг цэсийг хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмжийн хэмжээнд нийцүүлэн мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулж, батлуулах бөгөөд тусгаарлан ажиглах байрны менежерт хүргүүлэх;

4.1.4. тусгаарлан ажиглах түр байрны удирдлага, ажилтан, эрүүл мэнд, онцгой байдал, цагдаагийн алба хаагчдад халдвараас сэргийлэх дэглэм, гүйцэтгэх үүрэг, дэг журам сахиулахтай холбоотой сургалтыг ээлж солилцох бүрт зохион байгуулж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэмд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах;

4.1.5. авто болон төмөр замын боомтоор татан авах иргэдийн нэрсийн жагсаалтыг Монгол Улсаас Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар болон бусад холбогдох байгууллагаас урьдчилан авах;

4.1.6. гадаад улсаас иргэдийг татан авах, өөр улс орноор дамжин өнгөрүүлэх ажиллагааны төлөвлөгөөг тухай бүр боловсруулж, батлах;

4.1.7. тусгаарлан ажиглах түр байрны онцлог, багтаамж, давхар, өрөө тасалгаа, орны тоо, зохион байгуулалт, хүний тооноос хамаарч тухайн байранд ажиллах алба хаагчдыг хуваарилах;

4.1.8. гадаад улсаас ирж буй эрүүл мэндийн шалтгаантай зорчигчийг урьдчилан бэлтгэсэн эмнэлэг, бусад зорчигчийг тусгаарлан ажиглах байранд тээвэрлэн хүргэх тээврийн хэрэгслийг бэлтгэх;

4.1.9. тусгаарлан ажиглах түр байранд зайлшгүй шаардлагаар нэвтрэх ажилтан, албан хаагчдад /төрөлжсөн мэргэшлийн эмч мэргэжилтэн, өргөдөл, гомдлоор шалгалт хийх мэргэжлийн хяналтын улсын байцаагч, хэв журам сахиулах цагдаагийн алба хаагч, тусгаарлах байрны үйлчилгээ, цахилгаан, ус дулаан хангамж, мэдээлэл холбооны г.м/ зөвшөөрөл олгох;

4.1.10. тусгаарлан ажиглах түр байрны нөхцөл, дэг журам, эрүүл мэнд, хоол хүнсний асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг шалгаж шийдвэрлэх;

4.1.11. тусгаарлан ажиглах түр байрыг орчин нөхцөл, үйлчилгээний чанар, төлбөрийн нөхцөлөөс хамааруулан ангилсан судалгаа гаргаж, тусгаарлагдах хүнд санал болгох;

4.1.12. АСШШ-ыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, үүрэг, чиглэл өгч биелэлтийг хангуулах;

4.1.13. удаа дараа зөрчил дутагдал гаргасан нь нотлогдсон байгууллага, аж ахуйн нэгжийг тусгаарлан ажиглах түр байраар ажиллуулахгүй байх шийдвэрийг гаргаж, гэрээг цуцлах, гарсан хохирлыг нөхөн төлүүлэх;

4.1.14. тусгаарлан ажиглах түр байранд ажиллаж буй онцгой байдлын алба хаагчаас ажиглалт хийж буй хүний шилжилт хөдөлгөөний тоон мэдээ, эрүүл мэндийн ажилтнаас дэлгэрэнгүй бүртгэлийг өдөр бүр авч нэгтгэн, мэдээллийн санг бүрдүүлэх, тандалт, дүн шинжилгээ хийх;

4.1.15. тусгаарлан ажиглах түр байрнаас гэрийн тусгаарлалтад шилжих хүний бх-ПГУ шинжилгээний "сөрөг" гарсан сүүлийн хариуг ХӨСҮТ-өөс 11.00 цагаас өмнө

албан бичиг эсвэл цахимаар авч, энэ талаар тусгаарлан ажиглах түр байрны хамгаалалтын ажилтанд мэдэгдэх.

#### **4.2. Аймаг, сум, дүүргийн Шуурхай штаб дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:**

4.2.1. тусгаарлан ажиглах түр байрыг энэхүү журмын 3.6-д тавигдах шаардлагад нийцүүлэн сонгох, бэлтгэлийг хангуулах;

4.2.2. түр байрны өрөө тасалгаа, орны тоо, багтаамж, давхрын зохион байгуулалт, тоног төхөөрөмж хангалт, түр байрлах хүний тооноос хамаарч тухайн байранд ажиллах алба хаагчдыг хуваарилах;

4.2.3. тусгаарлан ажиглах түр байрны удирдлага, ажилтан, алба хаагчдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, халдвараас сэргийлэх сургалт зохион байгуулж, мэдээллээр хангах;

4.2.4. сэжигтэй тохиолдол болон эрүүл мэндийн шалтгаантай зорчигчийг эрүүл мэндийн байгууллагад, бусад зорчигчийг урьдчилан бэлтгэсэн тусгаарлан ажиглах түр байранд тээвэрлэн хүргэх тээврийн хэрэгслийг бэлтгэх;

4.2.5. хилийн боомтоор нэвтэрсэн хүнийг тухайн нутаг дэвсгэрт түр тусгаарлах арга хэмжээг зохион байгуулах.

#### **Тав.Тусгаарлан ажиглах түр байр (хуулийн этгээд), түүнд ажиллагсдын үүрэг**

##### **5.1.Тусгаарлан ажиглах түр байрыг хариуцаж буй хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ:**

5.1.1. түр тусгаарлагдах хүний мэдээллийг улс болон аймаг, сум, дүүргийн Шуурхай штабаас урьдчилан авч, тусгаарлан ажиглах түр байрыг бэлтгэж, тусгаарлалт авах хугацаанд ажиллах хоол үйлдвэрлэх, зөөх, цэвэрлэгээ үйлчилгээ хийх багийг томилон бэлэн байдлыг хангуулах;

5.1.2.тусгаарлан ажиглах түр байрны байршил, давхар, өрөө, тасалгаа, нийт орны тоогоор зураглал гаргаж улсын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Шуурхай штабт хүргүүлэх;

5.1.3.тусгаарлан ажиглах түр байрны цахилгаан, халаалт, усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, хог хаягдлын цуглуулалт, зайлуулалтын тасралтгүй байдлыг хангах;

5.1.4.түр тусгаарлагдсан хүн, ажиллагсдын хоол, хүнсний нийлүүлэлт, тээвэрлэлт, хадгалалт, үйлдвэрлэл, үйлчилгээнд хяналт тавьж, хоол, хүнс, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах;

5.1.5.улсын бүртгэлд бүртгэгдсэн, хаяг шошгын зөрчилгүй, хэрэглэх заавар тодорхой халдваргүйжүүлэх бодисоор батлагдсан зааврын дагуу угаалга, цэвэрлэгээг тогтмол хийх;

5.1.6.тусгаарлан ажиглах түр байранд ажиллах ажилтнуудын хувийн бэлтгэлийг бүрэн хангуулж, ээлж солихгүйгээр ажиллуулах;

5.1.7.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, хоол үйлдвэрлэлд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, дархлаажуулалт, дархлаа сэргээх 3 дахь тунд хамрагдаж 14 хоногийн хугацаа өнгөрсөн, сүүлийн 21 хоногийн өмнө өвчлөөд эдгэрсэн, бх-ПГУ шинжилгээнд бүрэн хамрагдсан тогооч, туслах ажилтанг ажиллуулах;

5.1.8.тусгаарлан ажиглах түр байранд үүрэг гүйцэтгэх эрүүл мэнд, онцгой байдал, цагдаагийн алба хаагчдын тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

5.1.9.тусгаарлан ажиглах түр байранд сэжигтэй тохиолдол илэрсэн үед хэрэглэх иж бүрэн хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл (комбинзон, N95 амны хаалт, нүдний шил, нүүрний хаалт, бээлий, малгай, гутлын гадуурх улавч зэрэг)-ийн нөөцийг бэлтгэх;

5.1.10.түр тусгаарлагдах хүний мэдээлэл, хувь хүний нууцыг задруулахгүй байх;

5.1.11.түр тусгаарлагдсан хүн гарсны дараа байр, өрөөнд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийж дараагийн хүнийг хүлээн авах бэлтгэлийг хангах;

5.1.12.нэг ээлжийн тусгаарлан ажиглалтын хугацаа дуусмагц 2 хоногийн дотор хяналтын камерын бичлэгийн хуулбарыг тагнуул, цагдаагийн байгууллагад шилжүүлэх.

## **5.2. Тусгаарлан ажиглах түр байрны хоол үйлдвэр үйлчилгээний ажилтан дараах үүрэг хүлээнэ:**

5.2.1.шуурхай штабаас боловсруулсан жишиг цэсэд нийцүүлэн 7 хоногийн хоолны цэс, технологийн картыг боловсруулж, байгууллагын удирдлагаар батлуулж, мөрдөж ажиллах;

5.2.2.хоол үйлдвэрлэлийг явуулахдаа эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг сайтар хангах, тогоочийн амны хаалт эсвэл шүлсэвч зүүх;

5.2.3.хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэм сайтар сахих, гарал үүсэл нь тодорхой, баталгаажилттай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хоол үйлдвэрлэлд ашиглаж, ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг хөтлөх;

5.2.4.бэлтгэсэн хоол, хүнсний цуврал бүрээс 150 гр-аас доошгүй дээжийг ариутгасан саванд авч битүүмжлэн хаяглаж, 4°C-ийн хэмд, 72 цагаас багагүй хугацаанд хадгалж, бүртгэл хөтөлсний дараа устгах;

5.2.5.хоолны сав, хэрэгслийг 2 хувийн содын уусмал эсвэл зориулалтын угаагч бодисоор цэвэрлэж, халдваргүйжүүлэх;

5.2.6.хоолыг зориулалтын халуун баригч бүхий битүүмжлэлтэй саванд хийж, зөөвөрлөх;

5.2.7.хоол зөөх тэргэнцэрийг 0.015 хувийн жавелион эсвэл хлор агуулсан бусад бодисоор тогтмол халдваргүйжүүлэх;

5.2.8.тусгаарлан ажиглах түр байранд ажиллаж буй бусад албан хаагч, ажилтантай шууд харьцахгүй, гал тогооноос бусад хэсэгт зорчихгүй байж, халдвараас сэргийлэх дэглэмийг чанд мөрдөх;

5.2.9.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гардан боловсруулдаг, үйлдвэрлэдэг, тээвэрлэдэг ажилтан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд 6 сар тутамд бүрэн хамрагдах;

5.2.10.өөрийн эрүүл мэндийн байдал, биеийн халуунд өдөр бүр хяналт тавьж, өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд тусгаарлан ажиглах түр байрны эмч мэргэжилтэнд яаралтай мэдэгдэх.

## **5.3.Тусгаарлан ажиглах түр байрны үйлчилгээний ажилтан дараах үүрэг хүлээнэ:**

5.3.1.тусгаарлан ажиглах түр байрны үйлчилгээний ажилтанг хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн сургалтад хамрагдах, халдваргүйжүүлэх бодисыг найруулах арга, биологийн шингэнтэй ажиллах чадварт суралцсан байх;

5.3.2.тусгаарлагдаж байгаа хүн шал болон бусад гадаргуу дээр бөөлжсөн, суулгасан тохиолдолд шингэнийг нэг удаагийн цаасан алчуураар шингээж авах, бүхэл хэсгийг хутгуур ашиглан хамж авсны дараа угаалгын бодистой халуун усаар угааж цэвэрлэн шалыг 0.015 хувь, ариун цэврийн өрөөг 0.03 хувийн жавелионы уусмал эсвэл хлор агуулсан бусад бодисоор халдваргүйжүүлэх;

5.3.3.цэвэрлэгээ, үйлчилгээ хийх, хог хаягдал цуглуулах үедээ нэг удаагийн халад, малгай, нүдний шил эсвэл нүүрний хаалт, нэг удаагийн амны хаалт хэрэглэх, нэг удаагийн бээлий дээр цэвэрлэгээний зузаан бээлий өмсөх;

5.3.4.хамгаалах хувцас, хэрэгслийг өмсөхийн өмнө, тайлсны дараа, ариун цэврийн өрөөнд орсны дараа, хоол идэхийн өмнө, цэвэрлэгээ, үйлчилгээ хийсний дараа гараа тогтмол угааж халдваргүйжүүлэх;



5.3.5.өрөөний үүдэнд гаргасан хатуу хог хаягдлыг тогтоосон цагийн хуваарийн дагуу цуглуулж, хог хаягдлын цэгт хүргэх;

5.3.6.халдвартай хог хаягдлыг шар өнгийн уутанд цуглуулан зөөвөрлөн түр хадгалах хэсэгт хүргэх, цэвэрлэгээ, үйлчилгээний дараа хамгаалах хувцас, хэрэгслийг зааврын дагуу тайлагнах;

5.3.7.тусгаарлан ажиглах өрөөний хаалганы гадна талын бариул, хонх, коридорын шал, явган хүний болон цахилгаан шат зэрэг хүний гар байнга хүрэлцэх гадаргууг өдөр бүр цэвэрлэж, халдваргүйжүүлэх;

5.3.8.цахилгаан шат, хаалганы дээд хэсэг, коридорын болон хүлээлгийн танхимын гар хүрэхгүй хэсгийг зориулалтын бодисоор шүршиж халдваргүйжүүлэх;

5.3.9.хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг тайлахгүйгээр өөрийн амрах байр болон бусад хэсгүүдэд зорчихгүй байх;

5.3.10.хоол үйлдвэрлэлийн хэсгээс хоол, цайг хүлээн авч, тусгаарлан ажиглаж буй өрөөний үүдэнд байрлуулсан тавиур дээрх аяга, тавагны гадаргууд хүрэхгүйгээр хоолыг аягалж түгээх;

5.3.11.хоол түгээх үед тусгаарлагдаж буй хүнтэй ойрын зайнаас харьцахгүй байх;

5.3.12.хоол түгээж дууссаны дараа хоолны сав, хэрэгслийг гал тогооны бохир хүлээн авах хэсэгт хүргэх.

#### **5.4. Тусгаарлан ажиглах түр байранд ажиллаж буй эрүүл мэндийн ажилтан дараах үүрэг хүлээнэ:**

5.4.1.ажил үүрэг гүйцэтгэхтэй холбоотой хууль тогтоомж, эрх зүйн акттай урьдчилан танилцаж, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж, байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалан ажиллах;

5.4.2.тусгаарлан ажиглах түр байрны өрөө, орны тоо, хуваарилалтад хяналт тавьж байршлаар нарийвчлан гаргасан судалгааны дагуу хүнийг байрлуулах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэмийг дагаж мөрдөх талаар заавар, зөвлөмж өгч тэмдэглэл үйлдэх;

5.4.3.ажиллаж буй төрийн албан хаагч болон ажилтнуудад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэмийн зааварчилга өгч, онцгой байдал, цагдаагийн албан хаагчдыг удирдан зохион байгуулах;

5.4.4.тусгаарлан ажиглах түр байранд байгаа хүнд шаардлагатай тохиолдолд эмнэлгийн анхны яаралтай тусламж үзүүлсэн бол "яаралтай тусламжийн хуудас"-ыг хөтлөн, эм, эмнэлгийн хэрэгслийн зарлагыг тухай бүр бүртгэх;

5.4.5.тусгаарлагдсан хүнээс батлагдсан загварын дагуу "Эмнэлзүйн шинж тэмдэг тандах хуудас" бөглүүлж авах (зайнаас тандалтын хуудас авах, зайны тандалт хийх);

5.4.6.өөрийн болон бусад (үйлчилгээний болон онцгой байдал, цагдаа) алба хаагчийн эрүүл мэндийн байдалд хяналт тавьж, өдөр бүр биеийн халууныг хэмжиж, эмнэл зүйн шинж тэмдэг илэрч байгаа эсэх тухай тэмдэглэл хөтлөх;

5.4.7.биеийн халуун хэмжих, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үед нэг удаагийн халад, малгай, эмнэлгийн амны хаалт, үзлэгийн бээлий, гутлын гадуурх улавч хэрэглэх;

5.4.8.коронавируст халдварын мутацлагдсан хувилбарын сэжигтэй тохиолдол илэрсэн үед иж бүрэн хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл (нэг удаагийн халад, нүүрний хаалт, бээлий, малгай, гутлын гадуурх улавч зэрэг)-ийг өмсөж эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх;

5.4.9.тусгаарлалтад байгаа хүнд ямар нэгэн зовуурь, эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн үед эмчийн үзлэг хийж, эрүүл мэндийг үнэлэх;

5.4.10.тусгаарлалтад байгаа хүнд эрүүл мэндийн төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ шаардлагатай бол харьяалах эрүүл мэндийн байгууллагад яаралтай мэдэгдэж, тусламж үзүүлэх;

5.4.11.тусламж, үйлчилгээ үзүүлсний дараа шар бүсэд хувийн хамгаалах хувцас, хэрэгслийг зааврын дагуу зөв тайлж, халдвартай хог хаягдлыг шар өнгийн уутанд хийх;

5.4.12.хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл өмсөхийн өмнө, тайлсны дараа, ариун цэврийн өрөөнд орсны дараа, хоол идэхийн өмнө, бохирдсон үед гарыг тогтмол угааж, халдваргүйжүүлэх;

5.4.13.тусгаарлан ажиглалтад байгаа хүн заналхийлэх, доромжлох, тавьсан шаардлагыг эсэргүүцэх, биед халдах зэрэг үйлдэл гаргасан тохиолдолд онцгой байдал болон цагдаагийн алба хаагчид нэн даруй мэдэгдэх;

5.4.14.тусгаарлан ажиглалтад байгаа хүний овог, нэр, нас, хүйс, аяллын товч түүх, холбоо барих утас, оршин суугаа гэрийн хаяг, тусгаарлалтад орсон, шилжсэн, гарсан огноо, эрүүл мэндийн мэдээлэл зэргийг УОК-ын Нэгдсэн шуурхай штаб, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Шуурхай удирдлагын нэгжийн Google.sheet файлын "Нэмэлт мэдээлэл" талбарт 24 цагийн дотор байршуулах;

5.4.15.тусгаарлан ажиглах түр байрны албан хаагч, ажилчдын үйл ажиллагаанд халдвараас сэргийлэх дэглэмийг мөрдүүлэх, хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлын талаар мэдээлэх.

#### **5.5.Тусгаарлан ажиглах түр байранд ажиллаж буй Онцгой байдлын алба хаагч дараах үүрэг хүлээнэ:**

5.5.1.дотоод үйл ажиллагаанд камерын хяналт тавьж, 24 цагийн турш аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндийн байгууллагын ажилчдад туслах, хамтран хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй халдвар хамгааллыг сахиулах;

5.5.2.хүний эрүүл мэнд, амь насанд аюултай нөхцөл үүсэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч ажиллах ба эмх замбараагүй байдал үүссэн тохиолдолд цагдаагийн байгууллагын алба хаагчтай хамтран ажиллах;

5.5.3.галын аюулгүй байдал, аврах зам, гарцын тэмдэг, тэмдэглэгээ, хэвийн ажиллагаанд хяналт тавих;

5.5.4.тусгаарлалтад байгаа хүнд ирсэн эргэлтийн эд зүйлсийг дундын бүс /шар/-ээс авч, эрүүл мэндийн ажилтан өгөх, буцаан авч цагдаагийн албан хаагчид хүлээлгэж өгөх;

5.5.5.шилжилт хөдөлгөөний мэдээг тухай шатны онцгой комиссын Шуурхай штабт өдөр бүр хүргүүлэх;

5.5.6.тусгаарлагдах хүнийг хүлээн авч, байрлуулахад эмч мэргэжилтэнд дэмжлэг үзүүлэх, хүний санал, гомдлыг амаар болон бичгээр хүлээн авч, тэмдэглэл хөтлөн шийдвэрлүүлэх;

5.5.7.тусгаарлан ажиглах түр байр болон өрөөнд зайлшгүй шаардлагаар нэвтэрч байгаа эмч мэргэжилтэн, бусад ажилтны талаарх мэдээллийг тухай бүр бүртгэж, тэмдэглэл хөтлөнө

5.5.8.үүрэг гүйцэтгэх хугацаанд өдөр бүр гарсан зөрчил, дутагдлын талаар холбогдох мэдээг УОК-ын Нэгдсэн шуурхай штабт 10:00 цаг, 18:00 цаг, 24:00 цагт өгч, тэмдэглэл хөтлөх;

5.5.9.тус журмын хэрэгжилтэд хяналт тавьж, ноцтой зөрчил илэрсэн тохиолдолд УОК-ын Нэгдсэн шуурхай штаб болон аймаг, нийслэлийн шуурхай штабт мэдээлэх.

## **5.6.Тусгаарлан ажиглах байранд ажиллаж буй цагдаагийн алба хаагч дараах үүрэг хүлээнэ:**

5.6.1.гадна орчинд хамгаалалтын бүс тогтоож, тэмдэг тэмдэглэгээг нийтэд харагдахуйц байдлаар байршуулан, хэв журам сахиулж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавьж, зөвшөөрөлгүй хүн, тээврийн хэрэгслийг хамгаалж байгаа объект, бүсэд нэвтрүүлэхгүй байх;

5.6.2. цагдаагийн алба хаагч нь тусгаарлах түр байранд байрлаж байгаа хүн зөрчил гаргаж шаардлага биелүүлэхгүй үед болон камерын хяналтаар илэрсэн зөрчлийг шалгаж хуулийн дагуу тухай бүрд арга хэмжээ тооцох;

5.6.3. түр байранд нэвтрэх шаардлагатай эмч мэргэжилтэн, эрх бүхий байгууллагаас зөвшөөрөлтэй албан хаагчийн ажлын үнэмлэх, хүчин төгөлдөр "бх-ПГУ шинжилгээний хариуг шалгаж, бүртгэл хөтлөн нэвтрүүлэх;

5.6.4. тусгаарлан ажиглах түр байранд хориглосон эд зүйлсийг нэвтрүүлэхгүй байх зорилгоор ачаа тээш, эд зүйлсэд үзлэг хийж гэрчээр онцгой байдлын алба хаагчийг байлцуулан тэмдэглэл хөтлөх;

5.6.5.энэхүү журмаар хориглосон эд зүйлсийг тусгаарлан ажиглах түр байранд нэвтрүүлэхгүй байх бөгөөд буцаах боломжгүй бол бүртгэл хөтлөн түр хадгалж, тусгаарлалтаас гарах үед эзэнд нь хүлээлгэн өгөх;

5.6.6. түр тусгаарлагдаж байгаа хүн болон үүрэг гүйцэтгэж буй бусад албан хаагчдад хууль ёсны шаардлага тавьж, гарсан гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, энэ талаар тэмдэглэл үйлдэн нэн даруй удирдах албан тушаалтанд мэдэгдэж, өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлэх;

5.6.7.хамгаалалтын бүсэд үүрэг гүйцэтгэх хугацаанд өдөр бүр Цагдаагийн ерөнхий газрын Шуурхай штабт 07:00, 18:00, 24:00 цагт мэдээ өгч, тэмдэглэл хөтлөх;

5.6.8.гадаад улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын эрх бүхий дипломат ажилтныг тусгаарлах тохиолдолд "Дипломат харилцааны тухай Венийн конвенц"-ийн 36 дугаар зүйлд заасныг баримтлах;

5.6.9.энэхүү журмын 6.6.8-д заасан хүний биед болон түүний ачаа тээшинд үзлэг хийх тохиолдолд Монгол Улсын Гадаад харилцааны яаманд мэдэгдэж, тухайн дипломат ажилтныг харьяалах Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, эсхүл түүний бүрэн эрхт төлөөлөгчийг байлцуулах.

## **5.7.Тусгаарлан ажиглах түр байранд байрлах хүн дараах үүрэг хүлээнэ:**

5.7.1.хуваарилсан өрөөнд байрлаж, тусгаарлалтын дүрэм, журмыг мөрдөх;

5.7.2.тусгаарлан ажиглах түр байранд ажиллаж буй албан хаагчдын хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

5.7.3.тусгаарлан ажиглах түр байранд орохоос өмнө өөрийн эрүүл мэндийн байдал, шашны зан үйлээр хориглосон болон харшлах, эм, эмийн хэрэгсэл, хүнсний бүтээгдэхүүний талаарх мэдээллийг урьдчилан мэдэгдэх;

5.7.4. түр тусгаарлагдах хугацаанд "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын лабораторийн оношилгооны түр заавар"-т тусгасан сорьц цуглуулах давтамжийн дагуу шинжилгээнд хамрагдах;

5.7.5.өөрийнхөө эрүүл мэндийн байдалд хяналт тавьж, коронавируст халдварын шинж тэмдэг илэрсэн тохиолдолд энэ талаар нэн даруй мэдэгдэх;

5.7.6.бусдын амгалан тайван байдлыг алдагдуулахгүй байж, эмч мэргэжилтэн болон бусад хүнтэй харьцах үедээ амны хаалт хэрэглэж, хүн хоорондын зайг барих;

5.7.7.өрөөний цонхны салхивчийг 2 цаг тутамд 15 минут нээж, агааржуулалт хийж, зааврын дагуу гараа тогтмол угааж, хувийн ариун цэврийг сайтар сахих;

5.7.8.зааварчилганы дагуу өрөөний цэвэрлэгээг өдөр тутам хийж, ахуйн хог хаягдлыг хуваарийн дагуу өрөөний үүдэнд гаргаж тавих;

5.7.9.байрны эд хогшлыг зориулалтын дагуу, ариг гамтай ашиглах, тухайн байгууллагын дотоод журамтай танилцаж гарын үсэг зурах;

5.7.10.өвчлөл бүртгэгдсэн гадаад улсаас ирсэн, өөр улс орноор дамжин ирсэн, дамжин өнгөрсөн хүн тусгаарлан ажиглах түр байрны нөхцөл, тавих шаардлагыг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд тарифын дагуу байрны төлбөрийг урьдчилан төлөх;

5.7.11.коронавируст халдвартай болох нь батлагдсан тохиолдолд өөрийн уулзсан хүн, явсан зам, чиглэлийн талаарх мэдээллийг үнэн зөв мэдээлэх, эмнэлэг болон эмнэлгийн зориулалтаар ашиглах байранд эмчилгээ, үйлчилгээнд хамрагдах;

5.7.12.бага насны хүүхэдтэй тусгаарлагдсан тохиолдолд түүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг бүрэн хариуцах;

5.7.13.тусгаарлан ажиглах түр байрнаас гарах үед өөрийн ачаа тээшний гадаргууг халдваргүйжүүлэх бодис бүхий уусмалаар арчиж халдваргүйжүүлэх;

5.7.14.ар гэрээс нь эргэлт өгөх боломжгүй үед тусгаарлан ажиглах түр байрны эрх бүхий ажилтанд хүсэлт гаргаж зөвшөөрөгдсөн эд зүйлсийг худалдан авч болно.

### **5.8. Тусгаарлан ажиглалтад байгаа хүнд дараах үйлдлийг хориглоно:**

5.8.1.ажилтан, алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, доромжлох, заналхийлэх, биед нь халдах, аливаа зүй бус үйлдэл гаргах;

5.8.2.бусдын эрүүл мэндэд хохирол учруулахуйц хурц үзүүртэй эд зүйл, архи, согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх, халуун бууруулах, өвчин намдаах эм, эмийн хэрэгсэл, бодис, түргэн гэмтэж, муудах хүнсний бүтээгдэхүүн, олон хүн тоглох тоглоом /хөзөр, хөлөгт тоглоом гэх мэт/ зэргийг авч орох, хэрэглэх, эргэлтээр авах;

5.8.3.өрөөнөөс гарах, өрөөний цонхоор хог, тамхины иш, нус, цэр, шүлсээ хаях болон эд зүйл дамжуулах, бусадтай харилцах, түр байрны эд хогшлыг санаатай болон санамсаргүй байдлаар эвдэх, эвдсэн тохиолдолд нөхөн төлөх;

5.8.4.бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах, өдөөн турхирах, буруу ташаа мэдээлэл санаатай тараах.

### **Зургаа. Тусгаарлан ажиглах түр байранд эргэлт оруулах**

6.1.Тусгаарлан ажиглах түр байранд байгаа хүнд энэ журмын 6.2-т заасан хориглоогүй эд зүйлсийг долоо хоногт нэг удаа эргэлтээр оруулж болно.

6.2.Тусгаарлан ажиглах байранд байгаа хүнд цагаан хэрэглэл, ахуйн болон ариун цэврийн хэрэглэл (шүдний оо, сойз, шампунь, ангижруулагч, саван, гоо сайхны бүтээгдэхүүн, алчуур, ариун цэврийн цаас, живх, амны хаалт, гар халдваргүйжүүлэгч бодис) хувцас, гутал, бичгийн хэрэгсэл, ном, сонин, сэтгүүл, гар утас, сим карт, нэгж, компьютер, техник хэрэгсэл, хүүхдийн тоглоом, чанар, эрүүл ахуйн шаардлага хангасан, зориулалтын савлагаатай, бүрэн бүтэн байдал нь алдагдаагүй, хүнсний бүтээгдэхүүн (талх, нарийн боов, чихэр, цай, кофе, ёотон, сүү, тараг, жимс, хүүхдийн сүүн тэжээл, нэмэгдэл хүнс г.м.) хүүхдийн угж, хооллох хэрэгсэл зэргийг гэрэлтдэг уутанд хийж, эд, зүйлсийн жагсаалт, тоо ширхгийг бичиж оруулахыг зөвшөөрнө.

6.3.Эргэлтийг 10:00-16:00 цагийн хооронд тусгаарлан ажиглах түр байрны тогтсон нэг хаалгаар хүлээн авч, халдваргүйжүүлсний дараа дотогш оруулна.

6.4.Эргэлтийг цагдаагийн болон онцгой байдлын албан хаагчид чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулж дамжуулна.

6.5.Эргэлтийн эд зүйлийг халдваргүйжүүлсний дараа цагдаагийн алба хаагч "ногоон" бүсэд хүлээн авч, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааны дагуу үзлэг хийн зөвшөөрөгдсөн эд, зүйлсийг завсрын буюу "шар" бүсэд хүргэх бөгөөд энэ журмын 5.8.2-т заасан хориглосон эд зүйлсийг буцаана.

6.6.Цагдаагийн албан хаагч дундын бүсэд эд зүйлсийг байршуулсны дараа онцгой байдлын алба хаагч хүлээн авч "улаан" бүсэд эмч мэргэжилтэнд дамжуулан өгнө.

6.7.Эргэлтийн эд зүйлийг буцаан гаргахгүй гэдгийг тусгаарлагдаж буй хүнд мэдэгдэнэ.

6.8. Тусгаарлан ажиглах түр байранд энэ журмын 5.8.2-т заасан эд зүйлийг оруулахыг хориглоно.

## **Долоо. Тусгаарлан ажиглах түр байранд сэжигтэй болон батлагдсан тохиолдол илэрсэн үеийн хариу арга хэмжээ**

7.1.Тусгаарлан ажиглах түр байранд тусгаарлагдсан хүнд коронавируст халдвар (КОВИД-19)-ын шинж тэмдэг илэрсэн үед хугацаа харгалзахгүй антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээ ажлыг нийслэлд Халдварт өвчин судлалын үндэсний төв /ХӨСҮТ/-ийн шуурхай хариу арга хэмжээний баг, орон нутагт харьяа Эрүүл мэндийн байгууллага зохион байгуулна.

7.2.Нэг өрөөнд тусгаарлагдсан 0-16 насны хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн аль нэгээс коронавируст халдварын батлагдсан тохиолдолд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлийн дагуу эрүүл мэндийн байгууллагад хамтад нь шилжүүлж болно. (Хэрэв тусгаарлан ажиглах түр байранд тусгаарлагдаж буй 0-1 насны хүүхэдтэй эх коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдолд өөрийн хүсэлтээр хүүхэдтэй хамт эмнэлэгт шилжүүлнэ)

7.3.Нэг өрөөнд тусгаарлагдсан гэр бүлийн болон хамт амьдарч, ажиллаж, сурч байсан хүмүүсээс сэжигтэй болон батлагдсан тохиолдол илэрвэл тухайн хүнийг эрүүл мэндийн байгууллагад шилжүүлж, бусад хүнийг өрөөнд нь тусгаарлах эсэхийг тандалтын багийн дүгнэлтийг үндэслэн тухайн шатны онцгой комиссын Шуурхай штаб шийдвэрлэнэ.

7.4.Голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлнэ. Мэргэжлийн хяналтын байгууллага хөндлөнгийн хяналт тавина.

7.5.Халдваргүйжүүлэлт хийсэн хэсгүүдийг зааврын дагуу тусгаарлан ажиглах түр байрны үйлчилгээний ажилтан угааж цэвэрлэнэ.

7.6.Тусгаарлан ажиглах түр байрны эрүүл мэндийн ажилтан нь батлагдсан болон сэжигтэй тохиолдлоор эмнэлгийн байгууллага руу хүргэгдсэн хүний мэдээллийг 1 цагийн дотор тухайн шатны Онцгой комиссын Шуурхай штабт тус тус мэдэгдэнэ.

7.7.Ганцаараа тусгаарлагдах боломжгүй /өөрийн үйлдлийг хянах чадваргүй, бүрэн бус чадвартай, тусгай хэрэгцээт хөгжлийн бэрхшээлтэй, хүнд өвчтэй, бага насны хүүхэд/ хүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тусгаарлан ажиглах түр байранд хамтад нь тусгаарлана.

7.8.Батлагдсан тохиолдлын эмнэлзүйн хэлбэрийг харгалзан эмнэлэгт нь тусгаарлан эмчилнэ.

7.9.Тусгаарлан ажиглах түр байранд батлагдсан тохиолдлыг ХӨСҮТ, нийслэлийн эрүүл мэндийн газар, орон нутгийн Шуурхай хариу арга хэмжээний баг тээвэрлэнэ.

### **Найм. Тусгаарлан ажиглах байрны халдваргүйжүүлэлт**

8.1.Урьдчилан сэргийлэх буюу өдөр тутмын халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагын гаргасан заавар, зөвлөмж, журмын дагуу хийж гүйцэтгэнэ.

8.2.Тусгаарлалтын нэг ээлж дууссаны дараах халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагын гаргасан заавар, зөвлөмж, журмын дагуу хийж гүйцэтгэнэ.

8.3.Тусгаарлан ажиглалтад орж байгаа хүнийг тээвэрлэсэн тээврийн хэрэгслийг мэргэжлийн байгууллага халдваргүйжүүлнэ.

8.4.Тусгаарлан ажиглах байранд 2 буюу түүнээс дээш тохиолдол голомтлон гарч коронавируст халдварын батлагдсан тохиолдлыг шилжүүлсний дараа тухайн хүний байрлаж байсан өрөө, ажилтны амралтын өрөө, явсан чиглэлийн дагуу коридор, шат, лифт, хаалганы хэсэгт голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг нийслэлд ЗӨСҮТ болон холбогдох мэргэжлийн байгууллага, аймагт ЗӨСТ, ЗӨСТ-гүй аймагт Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг, сум, тосгонд эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг гүйцэтгэнэ.

## **Ес. Тусгаарлан ажиглах түр байранд тавих хөндлөнгийн хяналт**

9.1. Мэргэжлийн хяналтын байгууллага нь тусгаарлан ажиглах байранд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

9.1.1. тусгаарлан ажиглах түр байрны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл, халдвараас сэргийлэх дэглэм, хоол хүнсний хангалт, аюулгүй байдлын талаар ирүүлсэн өргөдөл гомдол, удирдлагын шийдвэрийн дагуу болон явцын хяналт шалгалтыг хийж, зөрчил, дутагдлыг илрүүлэх, шалтгаан нөхцөлийг тогтоож, холбогдох арга хэмжээг авах;

9.1.2. тусгаарлан ажиглах түр байранд хийж байгаа халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээнд хяналт тавих;

9.1.3. батлагдсан болон сэжигтэй тохиолдол илэрсэн үед хийх голомтын эцсийн халдваргүйжүүлэлтэд хөндлөнгийн хяналт тавих;

9.2. Шаардлагатай тохиолдолд тусгаарлан ажиглах байрны хөндлөнгийн хяналтыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тагнуул, цагдаагийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

9.3. Тусгаарлан ажиглах түр байранд хяналт тавих хуулийн этгээд шаардлагатай тохиолдолд камерын бичлэгийг ашиглана.

## **Арав. Тусгаарлан ажиглах түр байрнаас гарсан хог хаягдлыг цуглуулах, түр хадгалах, тээвэрлэх, устгах ажиллагаа**

10.1. Тусгаарлан ажиглах түр байр, өрөө, хоол үйлдвэрлэл, харуул, үйлчилгээ, хяналтын ажилтны хэсгээс гарах ариун цэврийн цаас, шил, лааз, сав, хайрцаг зэрэг баглаа боодол, хүнсний ногооны хальс, хоолны үлдэгдлийг энгийн хог хаягдлын хар өнгийн уутанд цуглуулна.

10.2. Тусгаарлан ажиглах түр байранд үүрэг гүйцэтгэж байгаа эмч мэргэжилтэн, алба хаагч болон бусад ажилтны хэрэглэсэн хамгаалах хувцас, хэрэгсэл (нэг удаагийн амны хаалт, бээлий, халад, нүдний шил, нүүрний хаалт, малгай, гутлын улавч болон тарианы хөвөн, дуслын системийн зүүгүй хэсэг, живх зэрэг)-ийг шар өнгийн уутанд цуглуулна.

10.3. Тусгаарлан ажиглах түр байранд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн болон гэрийн нөхцөлд эмчилгээ хийлгэхэд хэрэглэсэн тарианы ампул, зүү, тариур зэрэг хурц үзүүр, иртэй хог хаягдлыг аюулгүй хайрцагт цуглуулна.

10.4. Халуун хэмжигч багажийн зай, өдрийн гэрэл, даралт хэмжигч зэрэг хүнд металл агуулсан, хугацаа дууссан, хагарч гэмтсэн, бохирдсон эм, халдваргүйжүүлэх бодис агуулсан сав зэргийг хүрэн өнгийн уутанд цуглуулна.

10.5. Тусгаарлан ажиглах байрнаас гарсан шар, хүрэн өнгийн ууттай болон аюулгүй хайрцагтай хог хаягдлыг өдөрт 1 удаа тухайн байрны хог хаягдал цуглуулах цэгт төвлөрүүлнэ.

10.6. Тусгаарлан ажиглах байрнаас гарсан ахуйн хог хаягдлыг энгийн хог хаягдлын журмаар цуглуулж, хадгалан тээвэрлэж устгана.

10.7. Тусгаарлан ажиглах байрнаас гарсан аюултай хог хаягдлыг нийслэлд тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага, орон нутагт тухайн орон нутгийн эрүүл мэндийн байгууллага авна.

## **Арван нэг. Бусад**

11.1. Ажил үүргийн хувьд олж мэдсэн байгууллага болон хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг албан тушаалтан, хүн санаатай болон санамсаргүй байдлаар задруулахгүй байх үүрэг хүлээнэ. ( гэрээ байгуулах)

11.2.Энэхүү түр журмыг зөрчсөн албан тушаалтан, хүн, хуулийн этгээдэд Гамшгаас хамгаалах тухай хууль, "Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хуулийг үндэслэн Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Иргэний тухай хууль, Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---